

Хайрын тухай Э. Фроммын үзэл

Доктор, профессор Р.Дарьхүү

Түлхүүр үг: итгэл, хүндэтгэл, өгөөмөр сэтгэл, тэвчээр, хариуцлага.

Орчин үеийн нийгэмд болон хүний амьдралд, эдийн засаг, улс төр, соёл, шинжлэх ухааны ололт амжилт улам өсч байгаа. Гэвч үүний зэрэгцээ бидний өдөр тутмын амьдралд сэтгэцийн хямрал, зовиур, муухай сэтгэл, шунал, уур хилэн, уйтгар гуниг, хэнэггүй дуулгаваргүй байх, атаа жетөө, өс хонзон, танхай байдал, хулгай дээрэм, гэмт хэрэг, хүчирхийлэл улам газар авч, алхам тутамд бэрхшээлтэй болж буй нь нууц биш. Энэ муу муухайг засч залруулах, бууруулахад ёс зүйн мэдлэг, боловсрол, хүмүүжил, чухал үүрэгтэй. Ялангуяа өнөөгийн бидний харилцаанд хүмүүсийн хайр хүндэтгэл, харилцан ойлголцол, итгэл, энэрэнгүй ёс зүй ихээхэн үгүйлэгдэх болжээ. Энэ бүхэн нь хайр хэмээх хүний оршихуйн чухал үнэт зүйлтэй салшгүй холбоотой юм.

Э. Фроммын хэлснээр, "хайр нь хүний төрлийг олсон хэний ч болов бодит бөгөөд эцсийн хэрэгцээ, хүн оршин тогтнохуйн асуудлуудад хариулт өгөх ухаалаг бөгөөд хангалттай хариулт юм."¹⁵⁴ Хайр нь хүнийг бусадтай нэгтгэж өгдөг хүч, ганцаардмал байдлаас ангижрахад тусалдаг сэтгэл санаа, оюун ухааны хүч мөн. Хайр нь эв нэгдэлд хүрэх нэг үндсэн арга хэрэгсэл билээ.

Мөн шинжлэх ухааны түүхэнд олон мэргэд хайр хэмээх ойлголтын сэтгэл судлал, ёс зүйн үндэслэлүүдийг эрж хайхад ихээхэн ач холбогдол өгч судалж иржээ. Гэтэл өнөөдөр ийм судалгааг ямар ч үр дүнгүй ажил хэмээн үл тоомсорлох байдал ч зарим талаар ажиглагддаг. Ингэснээрээ уг асуудлыг бүр эсрэгээр эргүүлж туйлшруулж, эрхэм дээд гэж юм юу ч үгүй, үнэн худал нь мэдэгдэхгүй тийм байдалд хүргэж, улмаар эмх замбараагүй, ёс зүйгүй, хайр хүндэтгэлгүй байдал улам ихэсч байгаа юм. Хайр ба ёс зүй нь зайлшгүй холбоотой. Хайр нь энгийн сэтгэл хөдлөл, мэдрэмж төдийгүй, хүний бие, сэтгэл, оюун ухааны олон талт үйл ажиллагааны нийлбэр цогц гэдэг өргөн утгаар авч үзэх нь зүйтэй.

Философид олон мянган жилийн өмнөөс хайрын талаар судалж ирсэн боловч хайр гэж чухамдаа юу вэ? Яагаад хайр байдаг вэ? Хайр юунд хэрэгтэй вэ? Юуг хайрлавал зохих вэ? Хайрын мөн чанар нь юунд орших зэрэг олон асуудлын хариултыг одоо болтол бүрэн гүйцэд олоогүй л байна. Эдгээр асуудалд философичид олон янзын хариулт өгч иржээ.

Хайрын асуудал нь маш өргөн хүрээтэй олон талтай, нарийн ээдрээтэй сонирхолтой асуудал мөн. Тийм ч учраас эртнээс эдүгээ хүртэл философичд хүн судлаачид, сэтгэл судлаачид зэрэг олон үеийн мэргэд нарийн судалж боловсруулсан мөнхийн сэдвийн нэг хайр юм. Философид эртний моистууд, буддизм, Платоноос эхлээд олон сэтгэгчид хайрын асуудлыг амьдралын үнэт зүйл, амьдралыг тэтгэгч хүч болох талаас судалж тайлбарласан бол, XX зууны философид Тейяр де Шарден, З.Фрейд нар хайр нь хоёрдмол утгатай, зөрчилтэй зүйл болохыг онцолж, хайр нь нэг талаас аз жаргалд тэмүүлэх, нөгөө талаас хамгаалалтгүй зовлон хэмээн үзжээ.

XX зуунд хайрын мөн чанар, бүтэц, онцлогийн талаар илүү тодорхой судалгааг хийсэн философич нь Э. Фромм юм. Тэрээр хайрын тухай философийн үзлийг шинэ шатанд гаргасан байна.

Философи үүсэн цагаас эхлэн эдүгээ хүртэл хайрын мөн чанарын асуудал философичдын сонирхлыг татаж байв, өргөн судлагдсан ч бас хуучраагүй сэдэв болно. Энэ талаар эртний хятадын философич Күнз "жэнь" хэмээх ойлголтоор, моизмд "даяар ерөнхий хайрын зарчим", буддизмд

¹⁵⁴ Э.Фромм. Хайрын амт. УБ., 1994. 18 дах тал

“нигүүлсэнгүй хайр”, жайнизмд “ахимса” буюу “амьтай бүхнийг хайрлах зарчим”, Платоны “эрос – хайр” буюу сайхан юманд хүрч эдлэх хайр, дундад зууны үеийн философи дахь Августины хайрын ёс зүй, шинэ үеийн философи дахь “цэвэр хайр дурлал”, хайр дурлал нь ёс суртахуунлаг үзэгдэл, шашны философид жинхэнэ хайр гагцхүү бурхан тэнгэрийн хүчний оролцоотойгоор байдаг бол, Э. Фроммын үзлээр, хайр нь хүний оршихуйн суурь хэрэгцээ мөн зэрэг янз бүрийн философийн баримтлалууд бий..

3. Фрейдийн психоаналитик онолд “хайр дурлалыг хоёрдмол утгатай, зөрчилтэй зүйл” гэж үзсэн. Түүний үзлээр, “нэг талаас хайр дурлал нь аз жаргалд тэмүүлэх тэмүүлэл, нөгөө талаас хамгаалалтгүй зовлон мөн. Хайр дурлал нь дурлаж байвал хүсэн шаарддаг, шаардахгүй бол дурлаж чадахгүй. Бэлгийн дур хүсэлгүй хайр дурлал байна гэвэл энэ нь хүний эсрэг болно.”

Жинхэнэ хайрын мөн чанар юунд орших вэ гэдгийг Э.Фромм судлаад, “энэ нь бусдаас авах бус, бусдад өгөх, санаа тавих, хүндэтгэл, итгэл, хариуцлага, мэдлэгтэй байх зэрэг үндсэн шинжүүдээр илэрдэг”¹⁵⁵ хэмээн үзжээ. Ийнхүү хайр нь мөн чанараараа ихээхэн нууцлаг зүйл болно. Хайр бол энгийн сэтгэл хөдлөл бус, бас хүний идэвхтэй үйл ажиллагаа билээ. Хайр бол сэтгэл, оюун санаа, ёс суртахууны олон талт нарийн нийлмэл үзэгдэл мөн. Хайр нь аливаа хүн хүний ертөнцтэй, бусад хүмүүстэй нэгдэх нэг арга хэрэгсэл юм.

Жинхэнэ хайр юунд орших вэ? Жинхэнэ хайр ямар шинжүүдээр илэрдэг вэ? гэсэн асуудал гол нь байгаа юм. Энэ талаар Э. Фромм оновчтой үзэл санааг дэвшүүлсэн буй. Түүний үзлээр, жинхэнэ хайр нь өөртөө дараахь үндсэн шинжүүдийг агуулна.

Хайр сэтгэлийн идэвхтэй шинжийг хамгийн ерөнхий байдлаар хайр сэтгэл бол юуны өмнө авах биш, харин өгөхийн нэр мөн гэсэн утгаар баталж болох билээ. Өгөх гэж юуг хэлэх вэ? Энэ асуултанд хариулах амархан мэт боловч энэ нь олон утгатай, ихээхэн ээдрээтэй асуудал юм. Энэ талаар хамгийн их дэлгэрсэн нэг буруу ойлголт бол өгнө гэдэг нь ямар нэгэн юмнаас татгалзах, ямар нэгэн юмаар дутагдах хохирох гэсэн санаа мөн гэж үздэг явдал мөн. Мөлжих буюу хуримтлах гэхээс илүү юм боддоггүй хүн л өгөх гэдгийг чухамхүү ийм байдлаар ойлгодог байна. Ашиг хонжоо харагч шинж бол зөвхөн ямар нэгэн юм авч байж л өгөхөд бэлэн байдаг. Тийм хүний хувьд оронд нь юу ч авахгүйгээр өгнө гэдэг бол мэхлэгдлээ гэсэн утгатай болдог байна. Ашиг олох гэсэн гол санаандаа хүрээгүй хүмүүс л өгөх гэдгийг хоосрол гэж үздэг байна.

Тийм учраас ийм маягийн ихэнх хүмүүс өгөхөөс татгалздаг юм. Зарим хүмүүс өргөл барьц өгөх журмаар сайн үйлс бүтээх нь байдаг. Тийм хүмүүс өгнө гэдэг хэцүү, тийм ч учраас хүмүүс өгөх ёстой гэж үздэг байна. Буян үйлдэж өгөх нь тэдний хувьд хохирол үзсэн үйлдэл байдаг. Авахаасаа өгөх нь чухал гэдэг хэм хэмжээг тийм хүмүүс баяр хөөр эдэлж суухаас гачигдаж зовж суух нь дээр гэсэн утгаар ойлгодог ажээ.

Э.Фроммын үзлээр, “Сайн сэтгэлт хүмүүсийн хувьд өгөх гэдэг нь огт өөр утгатай юм. Өгөх гэдэг бол хүч чадлаа дээд зэргээр дайчилж буйн илрэл мөн. Өгөх бүрийдээ би өөрийн хүч чадал, хөрөнгө зоорь, эрх мэдлээ эдэлж байдаг. Тийм их хүч чадалтай, амьдрах чадвартай байгаадаа би баяр баясгалан дүүрэн байдаг. Тэгээд ч би өөртөө итгэлтэй, ихээхэн хүч зарцуулах чадвартай, амьдрал маань сайн, баяр баясгалантай байдаг. Өгнө гэдэг бол хоосрохын нэр биш, харин ч өгснөөр миний амьдрах чадвар тод илрэн гарч байдаг учраас авахаасаа өгөх нь илүү баясал төрүүлнэ. Эх хүн хэвлийдээ байгаа хүүхэддээ өөрийгөө өгнө, нялх үрдээ сүүгээ өгнө, халуун бие махбодио өгнө. Эх хүн тэгж өгөхгүй байж чадахгүй”¹⁵⁶.

Материаллаг зүйл дээр авч үзвэл өгнө гэдэг баян байна гэсэн үг. Их юмтай хүнийг баян гэдэггүй, харин их өглөгч хүнийг баян гэнэ. Ямар нэгэн

¹⁵⁵ Э.Фромм. Хайрын амт. УБ., 1994. 42 дах тал

¹⁵⁶ Э.Фромм. Хайрын амт. УБ., 1994. 53 дах тал

юмаар дутагдчих бий гэж сэтгэл түгшиж байдаг харамч хүн бол хичнээн их юмтай ч гэсэн сэтгэл зүйн хувьд ядуу хоосон хүн мөн. Харин өөрийгөө өгч чаддаг аливаа хүнийг л баян хүн гэнэ. Тийм хүн өөрийгөө бусдад өглөг өгөгч хүн гэдгийнхээ амт шимтийг амсаж байдаг. Гагцхүү хүний наад захын хэрэгцээ хангаж чадах юмгүй хүн л бусдад материаллаг зүйл өгөхийн амт шимтийг амсаж үл чадна.

Нэг хүн өөр хүнд юм өгснөөрөө өөрийгөө, өөрт байгаа хамгийн үнэ цэнэтэй юмаа, бүхий л амьдралаа өгч байгаа хэрэг мөн. Гэхдээ үүнийг хүн өөрийн амьдралыг бусдад золиос болгон өгч байгаа явдал гэж үзэж болохгүй юм. Тэр хүн нөгөө хүндээ өөрт байгаа хэрэгтэй л гэсэн юмаа, баяр баясгалангаа, ашиг сонирхлоо, өөрийн ойлголт, мэдлэгээ, өөрт нь тохиолддог уй гашуу тэр бүхнээ өгч байгаа хэрэг юм.

Жинхэнэ хайрыг тодорхойлогч гол шинж нь өөрийнхөө амьдралыг бусдад өгснөөр тэр хүн бусдыг баяжуулж, түүний амьдрах чадвартай байх сэтгэлгээгий нь нэмэгдүүлж байгаа явдал юм. Тэр хүн авахын тулд өгч байгаа юм биш, өглөг өгснийхөө амт шимтийг хүн өөрөө аяндаа амсдаг. Өглөг өгснөөрөө тэр хүн нөгөө хүнд хариу өгөх сэтгэгдэл төрүүлэхгүй байж чадахгүй. Үнэн сэтгэлээсээ өгсөн л бол тэр хүн нөгөө хүний хариу өгсөн юмыг авахгүй байхын аргагүй. Хүнд юм өгөх нь нөгөө хүнийг мөн өглөгч болгож, улмаар амьдралд тохиолдох баяр баяслаа хоёул хуваалцдаг. Юм өгснөөр ямар нэгэн шинэ санаа төрөх бөгөөд тийнхүү юм өгөлцсөн хоёр хүн шинэ санаагаар баяжсан амьдралдаа сэтгэл хангалуун байдаг. Энэ нь хайрлаж дурлалцах үед дурлал бол дурлал төрүүлэх хүч мөн, харин тийм хүчгүй бол дурлал төрүүлж чадахгүй гэсэн үг юм.

Энэхүү хайрыг өгөх үйлдэл гэж ойлгож буй хүний дурлах чадвар нь хүний зан чанарын хөгжилтөөс хамаарна. Үүний тулд зан төлөвшил нь өндөр түвшинд хүрсэн хүн байх шаардлагатай бөгөөд тэгснээр хүн бусдыг мөлжиж, эд хөрөнгө хуримтлуулах гэсэн давилуун хүслэнгээсээ ангижирч, өөрт байгаа хүч чадалдаа итгэх итгэлийг олж, тавьсан зорилтдоо хүрэхийн тулд өөртөө зоригтойгоор найдаж чаддаг болно. Хүнд энэ чанар дутагдах тусам өөрийгөө бусдад өгөхөөс айна гэсэн үг.

Жинхэнэ хайрыг тодорхойлогч бусад шинжүүд гэвэл: бусдад *санаа тавих, хариуцлагатай байх, хөдөлмөрч байх, хүндэтгэл үзүүлэх, юм мэддэг байх* чанарууд болно.

Бусдад санаа тавих гэдгийг төрсөн хүүхдээ хайрладаг эхийн хайраас тодорхой харж болох билээ. Хэрэв эх хүн хүүхдийнхээ төлөө санаа тавьж байгаа нь бидэнд харагдахгүй бол, хэрвээ хүүхдээ тэжээх асуудлыг хайхарч үзэхгүй байгаа бол, хүүхдээ угаахгүй, сайн асрах талаар нэг их хичээл зүтгэл гаргахгүй байгаа бол түүний баталж хэлсэн ямар ч үг бидэнд үнэмшилгүй болохсон билээ. Харин хүүхдийнхээ төлөө санаа тавьж байгаа нь бидэнд илхэн харагдах аваас ямар ч байсан бид түүний хайранд үнэмших болно. Ингэж санаа тавих явдал адгуусан амьтныг, цэцгийг хайрлах хайрд ч мөн холбогдоно. Хэрэв ямар нэгэн эмэгтэй хүн цэцгэнд хайртай гэж бидэнд хэлэх боловч тэрхүү цэцгээ услахаа мартдаг нь бидэнд харагдах аваас түүний цэцгэнд хайртай гэдгийг бид үнэмшихгүй.

Түүнчлэн хайр гэдэг бол амьдрал хийгээд бидний хайрлан үздэг тэр юмыг хөгжүүлэхийг, идэвхтэй сонирхдог байхыг хэлнэ. Идэвхтэй сонирхол байхгүй бол хайр сэтгэл байхгүй. Мөн хайр сэтгэл, хөдөлмөр хоёр бол салшгүй холбоотой юм. Хүн бүр хайрладаг юмныхаа төлөө хөдөлмөрлөдөг. Хүн санаа тавьж хайрлах дур сонирхолтой байхаас уламжлан хариуцлагатай хандах асуудал гарч ирнэ. Эдүгээ хариуцлагатай байх гэдгийг ямар нэг байдлаар гаднаас нь тулган хүлээлгэсэн үүрэг мэт ойлгох явдал их байдаг. Гэвч хариуцлага гэдгийн жинхэнэ утга бол эхнээсээ аваад эцсээ хүртэл цэвэр сайн дурын хэрэг мөн. "Хариуцлагатай" байна гэдэг бол "хариуцахад" бэлэн байна гэсэн үг.

Хайрлах сэтгэлтэй хүн бас хариуцах сэтгэлгээтэй байдаг. Хүн өөрийнхөө төлөө хариуцлага хүлээдэг шигээ ойр дотныхоо бүх хүмүүсийн төлөө хариуцлага хүлээхийг ухаарсан байх ёстой. Эх, хүү хоёр дээр аваад үзвэл энэ хариуцлагаас уламжлан эх нь хүүгийнхээ төлөө, ялангуяа эрүүл мэнд, хүмүүжил, бие бялдрынх нь төлөө санаа тавихуйд хүргэдэг. Харин насанд хүрсэн хүмүүсийн хоорондын хайр сэтгэлийн хувьд гэвэл тэр нь гол төлөв нөгөө хүнийхээ сэтгэл санааны хэрэгцээг хангах шаардлагатай холбоотой гарч ирдэг байна.

Хайр сэтгэлд хүндэтгэл байхгүй бол хариуцлагаас уламжлан давуу байдалтай байх, ноёрхох гэсэн санаа төрж болох юм. Хүндэтгэх гэдэг бол айдас хүрэм зүйл ч биш, сүслэх зүйл ч биш, энэ бол уг хүнийхээ язгуур утгаар хүнийг яг байгаа чигээр нь таньж авах, түүний мөн чанарыг нь ухааран ойлгох чадвартай байхыг хэлнэ. Хүндэтгэнэ гэдэг бол нөгөө хүнийхээ хөгжих ёстой тэр л жамаараа өсч хөгжөөсэй хэмээн хүсч, тусалж дэмжих явдал юм..

Тийм ч учраас хүндэтгэлд дарлан мөлжих санаа байж болохгүй. Миний хайртай хүн надад тус хүргэхийн тулд биш, харин өөрийнхөө сайн сайхны төлөө, өөрийнхөө явах ёстой замаар өсч дэгжээсэй гэж хүсч дэмждэг байх хэрэгтэй.. Би нэгэнт өөр хүнд хайртай л бол тэр хүн миний хүслийн дагуу миний зорилтыг биелүүлэх хэрэгцээний хүн болсон байгаасай гэх бус, харин тэр хүн өөрөө байдгаараа байж, би түүнтэй нэг санаатай байх явдал юм. Би өөрөө бие даасан байдалтай байж, бусдын туслалцаагүйгээр би өөрөө хөл дээрээ зогсож чадсан байх, бусад хэн хүнийг эрхшээлдээ авах, ашиглах гэх хэрэгцээ надад байхгүй байх тийм нөхцөлд л хүндэтгэл байж болно.

Өөр нэг зүйл бол хүнийг мэдэхгүйгээр хүнийг хүндэтгэж чадахгүй, хэрэв мэдлэгээр залж чиглүүлж өгөхгүй бол санаа тавих, хариуцлагатай байх гэдэг нь сохортой адил болно. Олон янзын мэдлэг байдаг, өнгөц ашиг сонирхлоор хязгаарлагдах биш, бүр уг чанарт нь нэвтрэн ордог хайр сэтгэлтэй холбоотой мэдлэг гэж байна. Би өөрийнхөө хувийн сонирхлын хүрээнээс халин давж, бусад хүний жинхэнэ байдлыг харж чадсан нөхцөлд л энэ мэдлэгийг олж чадна.

Бидэнд хайр сэтгэлийн асуудалтай холбоотой мэдлэг бол бүр ч илүү чухал.. Хэдийгээр хүний амьдрал нь бүр биологийнхоо үүднээс гайхалтай бөгөөд нууцлаг зүйл байдаг боловч, хүн, ер нь хүний жам ёс нь хүнд өөрт нь ч ойр дотныхонд нь ч нэвтрэшгүй зүйл юм. Энэ нууцыг танин мэдэх нэг арга зам бол хайр мөн.

"Хүн юуг хайрлавал зохих вэ?" хүнд хайрлах зүйл олон байдгийн дотроос эх эцэг нь үр хүүхдээ хайрлах, үр хүүхэд нь эцэг эхээ хайрлах, эр, эм хүмүүсийн харилцан бие биенийгээ хайрлах, хүндэтгэх, ах дүүсийн хайр, өөрийгөө хайрлахуй, бидний гэр орон болсон байгаль эх дэлхийгээ хайрлах, эх орноо хайрлах хайр хамгийн чухал юм.

Э. Фроммын үзлээр, "Эхийн хайр бол бүр төрөлх чанараараа гарцаагүй байх үзэгдэл бөгөөд арчаагүй дорой амьтныг хайрлах хайр мөн. Олонхи хүүхэд эхийн хайрыг хангалттай амсаж аз жаргалтай байдаг. Эх бол бидний гарч орж байдаг гэр орон, байгаль, тэнгис далай гэсэн үг"¹⁵⁷. байдаг.

Түүнчлэн эцэг хүн бол хүүхдийн хувьд байгаль ертөнц нь болж чадахгүй ч, маш олон зүйлийг төлөөлж байдаг байна. Эцэг хүн бол ертөнцийг танин мэдэх аргыг хүүхдэд заагч юм. Эцгийн хайрын гол зарчим нь тэвчээртэй, хүлээцтэй, заналхийлсэн биш, нэр хүндэд тулгуурлаж байх явдал юм. Тэрхүү хайр нь хүүхдэд өөрийнхөө хүчийг улам бүр ухаарах сэтгэлгээ өгч, эцсийн эцэст өөрөө өөрийнхөө нэр хүндэд найдаж, эцгийн нэр хүндээс чөлөөлөгдөх боломжийг олгосон байх ёстой.

Ийнхүү эцэг, эх, үр хүүхэд харилцан бие биенээ хайрлаад зогсохгүй, бусад хүмүүсийг адил хайрлах ёстой. Хайрын нэг түгээмэл хэлбэр бол ах дүүсийн хайр

¹⁵⁷ Э.Фромм. Хайрын амт. УБ., 1994. 105 дах тал

юм.Энэхүү хайр нь Э.Фроммын хэлснээр, эрх тэгш хоёр хүний хоорондын хайр байдаг.Харин эр,эмийн хайр бол хүмүүс өөрсдийн үр удмыг үлдээх,амьдралыг үргэлжлүүлэхэд чиглэгдэж байдаг үзэгдэл билээ.Энэ талаар Э.Фромм хэлэхдээ:"Энэ хайр нь ерөөс нэг л хүнтэй нэгдэн нийлэх гэсэн утгатай бөгөөд хамгийн хуурамч хэлбэрийн хайр ч байж болох юм"¹⁵⁸ гэжээ.

Хайр бол агуу зүйл бөгөөд өөртөө эерэг,сөрөг олон үзэгдлийг агуулдаг нийлмэл үзэгдэл мөн.Тухайлбал,хайр нь нэг талаас сэтгэл харамгүй өгөөмөр зүйл,нөгөө талаас эзэгнэх (эзэмдэх) сэтгэлийг өөртөө агуулдаг.Энэхүү эсрэг тэсрэг талуудтай холбоотойгоор хайрыг өгөөмөр хайр ба хэрэгцээний хайр хэмээн ангилж болно.Өгөөмөр хайрын жишээ нь ,хариу нэхдэггүй хайр , эцэг,эхийн хайр,бурханы хайр гэх мэтолон буй.Тэгвэл хэрэгцээний хайр бол үүний эсрэг бөгөөд хувь хүний сул дорой байдал,өөртөө итгэлгүй байдал,ашиг хонжоо харахтай холбоотой хуурамч хайр юм.

Хайр бол амьд оюун ухаан ,хүний салшгүй чанар болно.Хайр бол хүний ахуйн нэг суурь хэрэгцээ билээ.Хайраас хагацаж,хайхрамжгүй,харьжсан уур амьсгалд өссөн, мөн тийм орчинд ажиллаж амьдарч буй хүний бүх амьдрал дарамттай,гэр бүл,нэйз нөхөд нь дотно хандсан ч өөнтөгч сэтгэлээр өөрийгөө ганцаардмал байдлаар ойлгодог.Тийм хүн өөрийн ахуйн таагүй байдал,орчлон хорвоо аюул зовлонгоор дүүрэн ,цаг ямагт сөрөг зүйлс байдаг мэтээр төсөөлж,өөрийгөө сэтгэлийн дарамтад оруулдаг байна.Түүнчлэн хайр дурлал нь зэсийг алт,ядууг баян болгон харагдуулах тийм шилийг хүний нүдэнд зүүдэг ид шидтэй зүйл билээ.

Энэ бүхнээс дүгнэж үзвэл,хайр нь хүний амьдралын гэрэл гэгээ,хүчирхэг хөдөлгүүр,идэвхтэй бүтээлч үйл ажиллагаа юм.Жинхэнэ хайр нь хүний амьдралд итгэл,хүндэтгэл,тэвчээр,сахилга бат,энэрэнгүй сэтгэл,аз жаргал,баяр баясгалан,эрч хүч зэрэг олон эерэг зүйлсийг бүтээж,тэр хэмжээгээр тухайн хүн танигдахгүй болтлоо өөрчлөгддөг. Нөгөө талаас хайргүйгээр амьдрал байхгүй мэт сэтгэж үзэн ядах,амиа хорлох явдал зэрэг олон төрлийн зовлон,бэрхшээл,дарамтыг дагуулдаг зөрчилт үзэгдэл юм.Хайр бол дан ганц сэтгэл зүйн үзэгдэл бус,хүний бие,оюун ухаан,мэдлэг,хүндэтгэл,итгэл,сахилга бат,үүрэг хариуцлагын нэгдэл болсон ээдрээтэй үзэгдэл юм.Хайр нь мөн чанараараа зөрчилт үзэгдэл болно.

Ном зүй

- Балашов.Л.Е.О любви.М.,2000.
- Э.Фромм.Хайрын амт.УБ.,1994.
- В.Губин.А.Некрасова.Философская антропология.М.,2000.

¹⁵⁸ Э.Фромм.Хайрын амт.УБ.,1994.93 дах тал